



# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1997 оны 3 дугаар сарын 05 өдөр

Дугаар 6-18

Улаанбаатар хот

## Нийслэлийн нийгмийн даатгалын газрын дүрэм батлах тухай

1. Монгол улсын Засгийн газрын 1996 оны 263 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 1997 оны Б/18 дугаар захирамжийг үндэслэн Нийслэлийн нийгмийн даатгалын газрын дүрмийг 1 дүгээр хэвсрэлтээр, тус газрын дэргэдэх гомдлын шаардлагын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хэвсрэлтээр тус тус баталсугай.

2. Албан хаагчдыг томилж, цалин нэмэгдлийг холбогдох журмын дагуу тогтоож ажиллахыг Нийгмийн даатгалын газар (н.Сумаахүү)-т даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1994 оны А/200 тоот захирамжийг хүчингүй бөлсөнд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД  
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.НАРАНЦАЦРАЛТ

62



**Нийслэлийн Нийгмийн Даатгалын  
Газрын дүрэм**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.Нийслэлийн Нийгмийн даатгалын газар нь /цаашид "газар" гэх/ нийслэлийн нутаг дэвсгэр дээр нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэх төрийн захиргааны орон нутгийн байгууллага юм.

2.Газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулиуд, түүнийг хэрэгжүүлэх талаар гарсан Засгийн Газар, Нийгмийн даатгалын Төв байгууллага,Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тогтоол, захирамж, газрын дүрмийг удирдлага болгон ажиллана.

3.Газар нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн орлого, зарлагын гүйцэтгэлийг хангаж, хяналт тавих, даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг тогтоож цаг тухайд нь олгох, нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлүүлэх, сургалт сурталчилгаа явуулах, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдийг аргачлал, арга зүй, заавар удирдлагаар хангаж ажиллана.

4.Газар нь Нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар, Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газрын удирлагын дор ажиллаж тэдгээрт ажлаа тайлагнана.

5.Газрын зөвлөлийг байгуулан ажиллуулж болно.

6.Газрын дэргэд ажил олгогч, даатгуулагч болон нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан саналын зөрүүг хянан шийдвэрлэх гомдлын шаардлагын орон тооны бус зөвлөл ажиллана. Тус зөвлөлийн дарга нь Газрын дарга байна.

7.Газрын даргыг Нийслэлийн Засаг даргатай зөвшилцөж Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга томилж, албан тушаалаас чөлөөлнө.

Газрын ажилтнуудыг газрын даргын тушаалаар ажилд томилох буюу чөлөөлнө.

8.Газрын дарга нь эрх хэмжээний асуудлаар тушаал гаргана.

9. Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

10. Газрын үйл ажиллагааны зардлыг нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоор санхүүжүүлнэ.

Төсөвт зардлаа Улсын нийгмийн даатгалын ерөнхий газраар батлуулна.

11. Газар нь нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, шимтгэлийн орлогыг бүрдүүлэх, нийгмийн даатгалын зарлага санхүүжилтийн талаар нийслэлийн Санхүү, Татварын албад, банктэй ажлаа нягт уялдуулан мэдээллээр хангах, тайлан мэдээг тогтоосон хугацаанд нь гаргаж өгөх зэргээр хамтран ажиллана.

### **Хоёр. Газрын үүрэг**

1. Нийслэлийн хэмжээнд нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих.

2. Нийслэлийн нь нутаг дэвсгэр дэхь ажил олгогч, даатгуулагчаас нийгмийн даатгалын шимтгэлийг зохих хугацаанд нь даатгалын сан тус бүрт оруулах, нийгмийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үүссэн үүргийн дагуу олгох тэтгэвэр тэтгэмж болон цэргийн тэтгэвэр тэтгэмжинд зориулж улсын төсвөөс олгох татаасыг авч даатгалын сангуудын орлогыг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх.

3. Дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийг удирдан даатгалын сангуудын орлого зарлагын төсвийг батлаж, өөрчлөлт оруулах, үйл ажиллагаанд нь үнэлэлт өгч, хяналт тавих шалган зааварлах, тэргүүний арга барилыг сурталчлах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авах.

4. Нийслэлийн нийгмийн даатгалын сангуудын хөрөнгийг хууль зүйд нийцүүлэн захиран зарцуулах, тайлан мэдээ, мэдээллийг тогтоосон журмын дагуу гаргаж байх.

5. Нийслэлийн хэмжээнд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран буюу дангаараа нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, таниулах, иргэдийг нийгмийн даатгалын талаар зохих мэдлэгтэй болгох арга хэмжээ авах.

6. Даатгалын сангуудын жилийн орлого, зарлагын төсөв, эрүүл мэндийн даатгалыг төр хариуцах иргэдийн хураамжид улсын төсвөөс олгох хөрөнгө болон нийгмийн даатгалын байгууллагын төсвийн төслийг жил бүр зохиож хугацаанд нь Улсын нийгмийн даатгалын ерөнхий газарт ирүүлэх.



7. Дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсүүдийг мэдээллийн сүлжээнд оруулах ажлыг зохион байгуулах.

8. Нийгмийн даатгалын байгууллагыг үнэнч шударга, санхүү, нийгмийн даатгал, бүртгэлийн ажлын зохих мэдлэгтэй, дадлага туршлагатай, чадварлаг боловсон хүчнээр бэхжүүлэх.

### **Гурав. Газрын эрх**

1. Нийслэлийн нутаг дэвсгэр дээр анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөөгүйгээс хөдөлмөрийн хөлсний орлогыг тодорхойлох боломжгүй болсон ажил олгогчид түүнтэй адилтгах үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа ажил олгогчийн төлөх шимтгэл хэмжээтэй адилаар шимтгэл ногдуулах.

2. Тогтоосон хугацаанд шимтгэл төлөөгүй ажил олгогчийн банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг хууль тогтоомжид заасны дагуу түр зогсоох,

3. Нийгмийн даатгалын байцаагчаас тавьсан актад заасан шимтгэл алданги, хүү торгуулийг хугацаанд нь төлөөгүй бол уг шимтгэл, алданги, хүү торгуультай тэнцэх хэмжээний хөрөнгийг зохих хууль тогтоомжийн дагуу гаргуулах.

4. Илүү төлсөн шимтгэлийг дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд суутган тооцох буюу шимтгэл төлөгч хүсвэл тооцоо хийснээс хойш 30 хоногийн дотор эргүүлж олгох.

5. Шимтгэл, алданги, хүү торгууль төлөхөөс зайлсхийсэн, шимтгэлийн мэдээ тайланг хугацаанд нь ирүүлээгүй, нийгмийн даатгалын байгууллагын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ аваагүй ажил олгогчид хуульд заасан хариуцлага хүлээлгэх.

6. Дүүргүүдийн нийгмийн даатгалын сан бүрийн зарцуулагдаагүй үлдэгдлийг зайлшгүй шаардлагатай тохиолдолд төвлөрүүлэн авч нэгдсэн журмаар хуваарилан зарцуулах.

7. Нийгмийн даатгалын хяналт хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, бусад холбогдох баримт бичгийг ажил олгогч болон даатагуулагчаас үнэ төлбөргүй гаргуулан авах.

8. Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны ажилдаа тэнцэж байгаа эсэхэд дүгнэлт өгөхийн гадна тэднийг ажлын үр дүнг нь харгалзан хууль тогтоомжид заасны дагуу шагнаж урамшуулах.

9. Гадаад орны ижил төрлийн байгууллагатай нийгмийн даатгалын асуудлаар ажил хэргийн холбоо тогтоож хамтран ажиллах.

10. Дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс гаргасан шийдвэр болон байцаагчийн тавьсан актыг үндэслэлгүй гэж үзвэл хүчингүй болгох буюу өөрчлөх.

11. Дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн даргыг тухайн дүүргийн Засаг даргатай зөвшилцөж томилж, чөлөөлөх.

Нийслэлийн Засаг даргын 1997 оны  
6.8 тоот захирамжийн 2-р хавсралт

**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН  
ДЭРГЭДЭХ ГОМДЛЫН ШААРДЛАГЫН  
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**



Зөвлөлийн дарга: - Нийслэлийн нийгмийн даатгалын газрын дарга

Нарийн бичгийн дарга: -Нийслэлийн нийгмийн даатгалын газрын нийг-  
мийн даатгалын байцаагч

- Гишүүд:
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн Нийгмийн халамж  
хариуцсан мэргэжилтэн
  - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын  
Санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
  - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын  
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн  
хуулийн асуудал хариуцсан зохион байгуулагч
  - Улаанбаатар хотын ҮЭ-ийн холбооны дарга
  - Улаанбаатар хотын Үйлдвэрлэлийн хоршоодын  
холбооны зөвлөлийн нарийн бичгийн дарга